


Хүний хувийн мэдээллийг хамгаалах нь

Аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан
гарын авлага

2023 он



Агуулга

- | | |
|----|---|
| 01 | Товч мэдэгдэл |
| 02 | Гарын авлагын тухай |
| 03 | Хүний хувийн мэдээллийн тухай ойлголт |
| 04 | Хүний хувийн мэдээллийг яагаад хамгаалах ёстой вэ? |
| 05 | Хүний хувийн мэдээлэл гэж юу вэ? |
| 06 | Хүний эмзэг мэдээлэл болон нууц гэж юу вэ? |
| 07 | Хүний хувийн мэдээлэлтэй харилцах нь |
| 08 | Байгууллагын үйл ажиллагаа ба Хүний хувийн мэдээлэл |
| 09 | Хүний мэдээллийг хамгаалахад хэрэгжүүлэх 7 алхам |
| 10 | Хураангуй зөвлөмж |



Хүний хувийн мэдээллийг хамгаалах нь (Гарын авлага, 2023)

Зохиогчийн эрх © 2023 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

Монгол улс, Улаанбаатар хот

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Бизнес ба Хүний эрх Азийн хөтөлбөрийн хүрээнд **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын** санаачилга, оролцоотойгоор **ПрайсуютэрхаусКүүпэрс** компаниас бэлтгэсэн болно. Тус гарын авлагыг зөвхөн хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар ерөнхий ойлголт, мэдээллийг өгөх зорилгоор бэлтгэсэн бөгөөд энд тусгагдсан мэдээллийг мэргэжлийн зөвлөгөөтэй адилтгаж болохгүй юм. Иймд эрх зүйн үр дагавар бүхий тухайлсан шийдвэр гаргахдаа мэргэжлийн зөвлөгөө авахыг зөвлөж байна. Гарын авлагад үндэслэн хийсэн таны аливаа үйлдэл, эс үйлдэхүйд бид хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү гарын авлага нь зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлэхгүй. Энэхүү гарын авлагад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү гарын авлагыг 2023 оны 9 дүгээр сард боловсруулсан тул түүнээс хойш гарсан эрх зүйн актуудыг нэмж судлах шаардлагатайг анхаарна уу.

Хүний эрхийн Үндэсний Комисс

Монгол Улс, Улаанбаатар 15170,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-2,
Засгийн газрын 12 дугаар байр
Утас: +976 7000 0222
<https://www.nhrcm.gov.mn>

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
Монгол Улс, Улаанбаатар 14201,
Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-14,
Нэгдсэн Үндэстний Байгууллага
Утас: +976 1132 7585
<https://www.undp.org/mongolia>

ПрайсуютэрхаусКүүпэрс Монгол (PwC)
Монгол Улс, Улаанбаатар 14100,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сэнтрал Тауэр, 6 давхарт 601
Утас: +976 7000 9089
<https://www.pwc.com/mn>

Гарын авлагын тухай

Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь улам чухал болсоор байна. Дэлхийн улс орнууд хүний хувийн мэдээллийн нууцлал хамгаалалтын тухай хууль тогтоомж баталж, энэ чиглэлээр хурдацтай өөрчлөлтийг хийж байна. Эдгээр хууль тогтоомж нь хүний хувийн мэдээллийг зөвхөн тодорхой зорилгоор, хуульд заасан үндэслэлээр л цуглуулж, боловсруулж, ашиглахаас эхлээд мэдээллийг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох дүрэм журмыг батлах зэрэг олон шаардлагыг тухайн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигласан этгээдэд тавих болжээ.

Монгол Улсын хувьд ч энэхүү шаардлагыг хуульчлан 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийг баталсан. Тус хууль нь 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.



Иймд аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү өөрчлөлтөд дасан зохицож, өөрсдийн үйл ажиллагаа болон дүрэм журмаа сайжруулах шаардлага бий болж байна.

Энэ гарын авлагыг хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагууд байгууллагуудад тавигдаж буй **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн** шаардлагуудыг ойлгох, тэдгээрийг мөрдөх явдлыг хялбарчлах зорилгоор бэлтгэсэн болно. Дээрхээс гадна гарын авлагад одоогийн практикийг үнэлэх, сайжруулахад шаардлагатай мэдээлэл болон бусад улс оронд хэрэгжүүлж буй сайн туршлагад үндэслэсэн зөвөлгөөг тусгасан болно.

Энэхүү гарын авлага нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, бизнесийн давуу талыг нэмэгдүүлэхийг зорьж буй бүхий л хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад зориулагдсан болно.

Хүний хувийн мэдээллийн тухай ойлголт



Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал (“МНАБ”) нь хүний халдашгүй байх эрхийн салшгүй хэсэг бөгөөд энэ хүрээнд хүмүүс өөрийн хувийн мэдээллийг нууцлах, хамгаалаулах, цаашлаад ямар хувийн мэдээллийг нь хэн цуглуулж, хэрхэн ашиглаж байгааг мэдэх болон хуульд заасны дагуу өөрийн мэдээллийг устгуулах буюу мартагдах эрхтэй юм.

Түүнчлэн, МНАБ-ыг хамгаалах асуудал нь зөвхөн хувь хүн өөрийнхөө мэдээллийг хамгаалахаар хязгаарлагдахгүй. Хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж буй байгууллагууд ч мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу МНАБ-ыг хангаж, ёс зүйтэй хандах ёстой.

Сүүлийн жилүүдэд томоохон компаниуд МНАБ-ын зөрчил гаргасны улмаас их хэмжээний торгууль төлсөн олон тохиолдлууд гарах болсноор олон нийтийн зүгээс МНАБ-д ихээхэн анхаарал хандуулах болсон.

2021 оны байдлаар дэлхийн улс орнуудын 71% буюу нийт 137 улс МНАБ-ын талаар тусгайлсан хууль баталсан байна.



Монгол Улс 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталснаар Хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болгосон. Хувь хүний нууцын тухай хуультай харьцуулахад **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль** нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг илүү өргөн хүрээг баталгаажуулсан, урьд өмнө байгаагүй нарийн зохицуулалттай болсон.

Түүнчлэн, **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль** нь Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуультай харилцан уялдаатай үйлчилж, Монгол Улсад кибер аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах цогц тогтолцоог бүрдүүлж байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр дараах журам, шаардлагууд батлагдсан. Энэ нь:

- Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам;
- Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам.

Харин дараах шаардлага, журмууд өнөөдрийн байдлаар хараахан батлаагүй төслийн шатанд байна.

- Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийн журам;
- Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага.

Хүний хувийн мэдээллийг яагаад хамгаалах ёстой вэ?



Техник технологи хөгжсөн өнөө үед хүний хувийн мэдээллийг нууцалж, хамгаалж чадаагүйн улмаас банкны мэдээллээ алдах, залилангийн гэмт хэргийн хохирогч болох, нууц мэдээлэл нь өөрийнх нь хяналтгүйгээр цахим орчинд тархах зэрэг олон төрлийн сөрөг үр дагавар бий болдог. Иймээс хүний хувийн мэдээллийн нууцлал, хамгаалалт нь өндөр ач холбогдолтой асуудал болжээ.

Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн үйлчлүүлэгч, ажилтан, болон харилцагч зэрэг хүний хувийн мэдээлэлтэй харьцаж байдаг тул мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэх дараах эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.



Санхүүгийн алдагдал

Монгол улсын хувьд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн тохиолдолд 5.000.000 - 20.000.000 төгрөг хүртэлх дүнгээр торгох зохицуулалттай байна.

Үүнээс гадна, аж ахуйн нэгж, байгууллага нь зөрчилтэй холбоотойгоор шүүхэд хариуцагчаар татагдсан тохиолдолд тус ажиллагаатай холбогдуулан шүүхийн зардал ч үүсэх боломжтой юм.



Хэвийн үйл ажиллагаа алдагдах

Аливаа байгууллага өөрийн үйлчлүүлэгчдийнхээ хувийн мэдээллийн аюулгүй байдалд хангалттай анхаардагдгүй эсвэл хүний хувийн мэдээллийг хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс зөрчил гаргасан тохиолдолд тухайн байгууллагын харилцагчид нэгэн зэрэг олон тооны гомдол, хүсэлтийг гаргах нөхцөл байдал бий болох боломжтой.

Ийнхүү ихээхэн гомдол, хүсэлтэд нэг бүрчлэн хариу өгөх шаардлагатай болсноор байгууллагын хэвийн үйл ажиллагаа удаашрах, алдагдах эрсдэлтэй байдаг.



Нэр хүндийн эрсдэл

аж ахуйн нэгж, байгууллага нь хүний хувийн мэдээлэл хамгаалах үүргээ биелүүлээгүй байдлаас болж аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд тухайн байгууллагын нэр хүнд унах, үйлчлүүлэгч, ажилчдынхаа итгэлийг алдах эрсдэлтэй.

Цаашлаад үйлчлүүлэгч, харилцагчдын тоо буурч, байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд ч сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болж болно.



Хяналт, шалгалт

Хууль зөрчсөний улмаас үүсэх үр дагавар нь зөвхөн тортголиар хязгаарлагддаггүй. Хууль зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор цагдаагийн байгууллага эсхүл бусад эрх бүхий албан тушаалтнууд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байдаг.

Дээрх зөрчил, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь мөн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах эрсдэлтэй.

Хүний хувийн мэдээлэл гэж юу вэ?



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ гэдэгт ямар мэдээлэл хамаарахыг улс орнууд тус тусын хуулиараа тодорхойлсон байдаг. Харин манай улсын хувьд дараах мэдээллийг хүний хувийн мэдээлэл гэж тодорхойлсон. Эдгээр нь:

ХҮНИЙ ҮНДЭС
УГСАА

ШАШИН ШҮТЛЭГ,
ИТГЭЛ ҮНЭМШИЛ

ЭРҮҮЛ МЭНД

ЗАХИДАЛ
ХАРИЛЦАА

ЭЦЭГ ЭХИЙН БА
ӨӨРИЙН НЭР

ТӨРСӨН ОГНОО,
ГАЗАР

ХӨРӨНГӨ

БОЛОВСРОЛ

ГИШҮҮНЧЛЭЛ

ЦАХИМ
ТОДОРХОЙЛОГЧ

ОРШИН СУУГАА
ХАЯГ БАЙРШИЛ

ТООН ГАРЫН
ҮСГИЙН ХУВИЙН
ТУЛХҮҮР

ИРГЭНИЙ
БҮРТГЭЛИЙН
ДУГААР

ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА
ЭСВЭЛ ЭДЭЛСЭН
ЭСЭХ

ГЕНЕТИК
МЭДЭЭЛЭЛ

БИОМЕТРИК
МЭДЭЭЛЭЛ

БЭЛГИЙН БА ХҮЙСИЙН ЧИГ БАРИМЖАА, ИЛЭРХИЙЛЭЛ, БЭЛГИЙН ХАРЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

**ХҮНИЙГ ШУУД ТОДОРХОЙЛСОН,
ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖТОЙ
МЭДЭЭЛЭЛ**

Зөвхөн тухайн мэдээллийг ашиглан тодорхой нэг хүнийг шууд тодорхойлох. **Жишээ нь:** регистрийн дугаар, цахим шуудан г.м.

**ХҮНИЙГ ШУУД БУСААР
ТОДОРХОЙЛСОН, ТОДОРХОЙЛОХ
БОЛОМЖТОЙ МЭДЭЭЛЭЛ**

Олон эх сурвалжаас авсан өөр өөр мэдээллийг нэгтгэх замаар хүнийг тодорхойлох. **Жишээ нь:** ажилтны үнэмлэхийн дугаар, машины дугаар г.м.

Цахим тодорхойлогч гэж юу вэ?

Хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээлэл.

Жишээлбэл: хүний цахим шуудангийн хаяг, фейсбүүк хаяг, банкны апликацийны нэвтрэх нэр, IP хаяг зэрэг нь тухайн хүний хувийн мэдээлэлд багтана.



Хүний эмзэг мэдээлэл болон нууц гэж юу вэ?

Хүний зарим хувийн мэдээлэл нь **ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ** буюу тухайн мэдээллийг задруулсан эсвэл буруугаар ашигласан тохиолдолд тухайн хүнд ноцтой сөрөг үр дагавар учруулж болзошгүй мэдээлэл байдаг. Манай улсын хувьд дараах хүний хувийн мэдээллийг эмзэг мэдээлэлд тооцдог.



Үндэс угсаа

Шашин шүтлэг,
итгэл үнэмшил

Эрүүл мэнд

Захидал харилцаа

Генетик ба
биометрик
мэдээлэл

Тоон гарын үсгийн
хувийн түлхүүр

Ял эдэлж байгаа
болон ял эдэлсэн
эсэх

Бэлгийн ба хүсийн
чиг баримжаа,
илэрхийлэл,
бэлгийн харьцаа



Генетик мэдээлэл
биологийн сорьцын
шинжилгээгээр тогтоосон
хүний бие махбод, эрүүл
мэнд, өвлөн авсан
удамшлын шинж чанарыг
илэрхийлсэн дахин
давтагдашгүй мэдээлэл
Жишиглэл: ДНХ



Биометрик мэдээлэл
тоног төхөөрөмж, техник хэрэгсэл,
программ хангамжийн
тусламжтайгаар хүний тодорхойлох
боломжтой гарын хурууны хээ,
нүдний солонгон бүрхэвч, нүүр
царай, дуу хоолой, биеийн
хөдөлгөөний онцлог шинж зэрэг
хүний бие махбодтой холбоотой
биеийн давхцахгүй өгөгдөл

Хүний **НУУЦ** мэдээлэлд халдсан эсхүл задруулсан тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээнэ. Хүний нууцад дараах мэдээлэл орно: Үүнд:



Эрүүл мэнд



Захидал харилцаа



Генетик мэдээлэл



Биометрик мэдээлэл



Тоон гарын үсгийн хувийн түлхүүр



Бэлгийн болон хүсийн чиг
баримжаа, илэрхийлэл



Бэлгийн харьцааны талаарх
мэдээлэл

Монгол Улсын

Эрүүгийн хуулийн

13.10 дугаар зүйл.Хувь

хүний нууцад халдах

гэмт хэрэг

13.11 дүгээр зүйл.Хувь

хүний нууцыг

задруулах гэмт хэрэг

Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах



Жишээлбэл, та сургалтад бүртгүүлэхээр өөрийн нэр, холбоо барих мэдээлэл зэргийг сургалтын байгууллагад өгч байгаа нь сургалтын байгууллагын зүгээс мэдээлэл цуглуулж буй хэлбэр юм. Харин тухайн мэдээллийг Excel файл дээр нэгтгэн сургалтад оролцогч нарын мэдээллийг оруулах нь мэдээлэл боловсруулж байгаа хэлбэр юм. Хэрэв сургалтын байгууллага нь таны мэдээллийг бусдад дамжуулсан тохиолдолд энэ нь мэдээллийг ашигласан явдал болно.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД



МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН гэж хэн бэ?

Тухайн мэдээллээр тодорхойлогдож байгаа хувь хүн, зарим иргэний хувьд түүний хууль ёсны төлөөлөгч.



МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ гэж хэн бэ?

Хуульд зааснаар эсвэл мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж буй хувь хүн, байгууллага.



МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧ гэж хэн бэ?

мэдээлэл хариуцагчийн өмнөөс мэдээлэл боловсруулж буй этгээд.

Аж ахуйн нэгж, байгууллагууд нь мэдээлэл хариуцагч эсвэл боловсруулагчийн хувьд мэдээлэлтэй харьцаж байдаг.



Жишээлбэл, Иргэн Цэцгээ гоо сайхны бүтээгдэхүүн худалдаж авахаар нэгэн онлайн дэлгүүрийн вэбсайтад шинэ хэрэглэгчийн бүртгэл нээлгэн, хувийн мэдээллээ оруулсан байна. Тус онлайн дэлгүүр нь “cloud drive”-ийн үйлчилгээ үзүүлдэг “Мишээл” компанийн үйлчилгээг авч, хэрэглэгчдийнхээ мэдээллийг хадгалдаг. Энэ тохиолдолд Цэцгээ **МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН**, онлайн дэлгүүр нь **МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ**, харин “Мишээл” компани нь **МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧ** болох юм.

Байгууллагын үйл ажиллагаа ба Хүний хувийн мэдээлэл



Аж ахуйн нэгж, байгууллага ямар ҮНДЭСЛЭЛЭЭР хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болох вэ?

01 Гэрээ

Гэрээ байгуулах ба байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор.

02 Тодорхойлох боломжгүй болгох

Түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл, нээлттэй өгөгдэл, статистик мэдээ бэлтгэх зорилгоор цуглуулж, боловсруулж, ашиглаж болно.

03 Ил тод мэдээлэл

Тухайн мэдээллийг хуульд заасны дагуу нийтэд ил болгосон тохиолдолд болно.

04 Хуульд заасан үндэслэл

Хуульд хүний хувийн мэдээллийг ашиглах, цуглуулах, боловсруулахаар заасан бол болно.



05 Хөдөлмөрийн харилцаа

Хуульд заасан тохиолдолд хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцагч эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх зорилгоор.

06 Зөвшөөрөл

Дээрх үндэслэлээс бусад тохиолдолд зөвхөн мэдээллийн эзнээс зөвшөөрөл авснаар ашиглаж, цуглуулж, боловсруулна.



Хүний эмзэг мэдээллийг ямар тохиолдолд цуглуулж, боловсруулж, ашиглаж болох вэ?

Дээр дурдсан 6 үндэслэлээр хүний эмзэг мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахыг хуулиар зөвшөөрдөг. Үүнээс гадна дараах үндэслэлээр хүний эмзэг мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахыг хуульд зөвшөөрсөн. Энэ нь:

- тухайн хүн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтан хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх;
- иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагад хуульд заасны дагуу тайлбар, мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх.



Цаг бүртгэлийн зорилгоор ажилтны хурууны хээг ашиглаж болох уу?

БОЛОХГҮЙ.

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хүний эмзэг мэдээллийг (хурууны хээ) хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 2,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 20,000,000 тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мөн, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан гарын хурууны хээг устгах ёстой.



Сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах



Сэтгүүл зүйн, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болно.

Сэтгүүл зүйн болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мэдээллийг цуглуулж, ашиглаж, боловсруулахдаа зөвшөөрөл авах шаардлагатай юу?

Сэтгүүл зүйн, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болохыг хуулиар зөвшөөрсөн хэдий ч дараах мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах бол зайлшгүй мэдээллийн эзнээс **ЗӨВШӨӨРӨЛ** авах ёстой.

Үндэс угсаа	Шашин шүтлэг, итгэл үнэмшил	Эрүүл мэнд	Захидал харилцаа
Генетик ба биометрик мэдээлэл	Тоон гарын үсгийн хувийн түлхүүр	Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх	Бэлгийн ба хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцаа



АНХААРАХ!

Сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахдаа мэдээллийн эзэн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй.



Хариуцлага

Дээрх хуулийн шаардлагуудыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу дараах гэмт хэргүүдэд ял оногдуулна.

Үүнд:

- 13.8 дугаар зүйл. **Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу дүрс дамжуулах, тараах**
- 13.10 дугаар зүйл. **Хувь хүний нууцад халдах**
- 13.11 дугаар зүйл. **Хувь хүний нууцыг задруулах**
- 13.14 дугаар зүйл. **Худал мэдээлэл тараах**

Дээр дурдсан гэмт хэргүүдэд хүлээлгэх хариуцлага нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял зэргийн аль нэг байхаар хуульд заасан байдаг.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу дараах зөрчилд шийтгэл оногдуулна.

Үүнд:

- 6.27. дугаар зүйлийн 3 дах хэсэг - Хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг **2,000,000** төгрөгөөр, хуулийн этгээдийг **20,000,000** төгрөгөөр торгоно.**

Хүний хувийн мэдээллийг хамгаалахад хэрэгжүүлэх 7 алхам

1
Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах

2
Мэдээллийн эзний хүсэлтэд хариу өгөх

3
Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

4
Зөрчлийг мэдэгдэх

5
Мэдээлэл боловсруулагчтай харилцах

6
Дуу, дүрс, дуу-дүрсний бичлэг систем ашиглах

7
Мэдээлэл хамгаалах журам, үйл ажиллагаа, хэрэгжилтийг хангах



1 Мэдээллийн эзний зөвшөөрлийг авах

Мэдээлэл хариуцагч **хуульд зааснаас бусад үндэслэлээр** мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс **зөвшөөрөл** авна.

Түүнчлэн, анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээллийг боловсруулах, ашиглах тохиолдолд мэдээллийн эзнээс дахин зөвшөөрөл авах ёстай. Өмнө нь мэдээллийг дамжуулах зөвшөөрөл аваагүй бол мэдээллийн эзнээс мэдээллийг дамжуулах талаар дахин зөвшөөрөл авна.



Зөвшөөрлийг хэнээс авах вэ?



Мэдээллийн эзэн буюу тухайн мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнээс зөвшөөрлийг авна.



Мэдээллийн эзний хууль ёсны төлөөлөгч буюу насанд хүрээгүй эсвэл иргэний эрх зүйн чадамжийг нь шүүхээс хязгаарласан хүний мэдээллийг цуглуулахад түүний хууль ёсны төлөөлөгч буюу эцэг эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн зөвшөөрлийг авна.



Зөвшөөрлийн хэлбэр



Мэдээллийн эзнээс зөвшөөрлийг **бичгээр** авах бөгөөд

- цаасан, эсвэл
- цахим хэлбэртэй байна.


Зөвшөөрлийг авахын тулд танилцуулах мэдээлэл

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах **үндэслэл, зорилго**;
- Мэдээлэл хариуцагчийн нэр, **холбоо барих мэдээлэл**;
- Цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн **жагсаалт**;
- Мэдээлэл боловсруулах, ашиглах **хугацаа**;
- Мэдээллийг нийтэд **ил болгох** эсэх;
- Мэдээллийг бусдад **дамжуулах** эсэх, дамжуулах бол мэдээллийн жагсаалт, хүлээн авах этгээд;
- Зөвшөөрлийг **цуцлах** хэлбэр.



Зөвшөөрлийг цуцлах

Мэдээллийн эзэн өгсөн аливаа зөвшөөрлөө хэдийд ч цуцалж болох ба цуцлах тухай хүсэлтийг хүлээн авснаас өмнөх хугацаанд хийгдсэн мэдээлэл боловсруулалт нь хууль ёсны хэвээр үлдэнэ.



2 Мэдээллийн эзний хүсэлтэд хариу өгөх

Мэдээллийн эзэн өөрийн эдлэх дараах эрхийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагад хүсэлт гаргах боломжтой ба мэдээлэл хариуцагч эдгээр хүсэлтэд хариу өгөх шаардлагатай юм.

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЭРХҮҮД

Мэдээлэл өгөхөөс татгалзах

Хувийн мэдээллээ мэдэх

Хувийн мэдээллийг нь цуглуулсан, боловсруулсан, ашигласан эсэхийг мэдэх

Мэдээллийг хуулийн дагуу цуглуулахыг хоригlossen, устгах ёстой тохиолдолд хэрэгжүүлэхийг шаардах

Мэдээллийг устгуулах буюу мартагдах

Мэдээллээ дамжуулах

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад цуцлах хүсэлт гаргах



Хувийн мэдээллийг дамжуулсан талаар болон, хулээн авсан этгээдийн талаар мэдэх

Мэдээллээ запруулах

Мэдээлэл цуглуулах, дамжуулах зөвшөөрлийг өгөх, өгөхөөс татгалзах

Хувийн мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас гаргуулан авах

Мэдээллийг боловсруулсны үр дунд гарсан шийдвэрт гомдол, тайлбар гаргах



ХҮСЭЛТЭД ХАРИУ ӨГӨХ АЛХМУУД



Мэдээллийн эзний тодорхойлох. Цахим орчинд эсвэл иргэний үнэмлэх, адилтгах бичиг баримтаар мэдээллийн эзэн эсвэл хууль ёсны төлөөлөгч мөн эсэхийг баталгаажуулна.



Хүсэлтийг шийдвэрлэх. Мэдээллийн эзэн, түүний төлөөлөгч мөн болох нь тогтоогдсон тохиолдолд хүсэлтийг нь холбогдох ажилтан, хэлтэст дамжуулж шийдвэрлэнэ.



Хүсэлтийн хариуг баримтжуулах. Мэдээллийн эзний хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар бүртгэлд тэмдэглэнэ.

АНХААРАХ!

Мэдээллийн эзний мэдээллээ устгуулах (мартаагдах) хүсэлтийг шууд хүлээн авч устгах болох уу?

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд хүний хувийн мэдээллийг устгах нөхцөлийг заасан тул эдгээр нөхцөлүүдийг харна. Мөн хуульд тусгайлан хадгалах хугацаа заасан мэдээлэл эсэхийг нягталсны үндсэн дээр мэдээллийн эзэнд хариу өгөхийг анхаарна уу.

3 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиар мэдээлэл хариуцагчид мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хэрэгжүүлэх ёстой хэд хэдэн арга хэмжээг хуульчилсан байна.

01

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах **дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдөх**;

02

Мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх **төлөвлөгөөг** батлах;

03



Хэрэглэгдэх мэдээллийн **системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах арга хэмжээ авах**;

04

Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар **журам, зааварчилгаа** баталж, мөрдөх;

05

Мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны **аюулгүй байдлыг хангах зорилгоор үнэлгээг хийх**.



4 Зөрчлийг мэдэгдэх

Мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил буюу хүний хувийн мэдээллийг хамгаалаагүй зөрчил гэдэгт мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг алдагдуулсан буюу хувийн мэдээллийг алдах, өөрчлөх, задруулах, устгах, зөвшөөрөлгүй үзэхэд хүргэсэн зөрчлийг ойлгоно.

Зөрчил гэдэг нь зөвхөн хувийн мэдээллийг алдахаас илүү өргөн хүрээтэй бөгөөд мэйл, шууданг буруу хүлээн авагч руу явуулах санамсаргүй алдаанаас эхлээд хувийн мэдээллийг олж авахын тулд цахим халдлага үйлдэх гэх мэт санаатай үйлдлүүд хамаардаг.



01

Зөрчлийг шалгаж, хүний хувийн мэдээлэлтэй холбогдсон эсэхийг баталгаажуулах.

02

Зөрчлийн үр дагаврыг үнэлж, хүний эрх, ашиг сонирхолд хохирол учруулах эсэхийг үнэлж тодорхойлох.

03

Зөрчил илэрвэл мэдээлэл хариуцагч ямар арга хэмжээ авах вэ?

04

Зөрчил ба авсан арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, **ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССИСТ ЖИЛ БҮРИЙН 1 ДҮГЭР САРД** хүргүүлэх.


Хариу арга хэмжээ авах.

Гэхдээ зөвхөн хүний эрх, ашиг сонирхолд хохирол учруулахаар гэж үзсэн бол мэдээллийн эзэнд мэдэгдэх үүрэгтэй.



Зөрчлийн талаар мэдэгдэлд тусгах мэдээлэл

1. Зөрчилд хамаарах мэдээллийн эзэн, мэдээллийн бүртгэл;
2. Мэдээлэл хариуцгачийн нэр, холбоо барих мэдээлэл;
3. Зөрчил, түүний улмаас учирч болзошгүй сөрөг үр дагавар;
4. Үр дагаврыг арилгахаар авсан хариу арга хэмжээ.



Мэдээлэл боловсруулагч ямар үүрэгтэй вэ?

Хэрэв та мэдээлэл хариуцагч биш, **мэдээлэл боловсруулагч** бол мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчлийг мэдсэн даруйд энэ тухай мэдээлэл хариуцагчид мэдэгдэх ёстойг анхаарна уу.

5 Мэдээлэл боловсруулагчтай харилцах

Өмнө нь дурдсанчлан, мэдээлэл хариуцагч нь гэрээний үндсэн дээр мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гуравдагч этгээд буюу мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно.



Мэдээлэл боловсруулагчтай байгуулах гэрээнд заавал тусгах нөхцөл:

- мэдээлэл цуглуулах, боловсруулах зорилго,
- гэрээний хугацаа,
- мэдээллийн жагсаалт,
- мэдээллийн эзний эрхийг хамгаалах нөхцөл
- Дээрхээс гадна мэдээлэл боловсруулагчид тавигдах нөхцөл, шаардлагыг тусгах нь зүйтэй.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧИЙН ҮҮРЭГ



Мэдээллийн эзний зөвшөөрлийн хүрээнд мэдээлэл хариуцагчийн хяналт доор мэдээлэл цуглуулах, боловсруулах;



Мэдээллийг мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу засах, өөрчлөх, устгах;



Мэдээлэл цуглуулах, боловсруулахад холбогдох шаардлагатай мэдээллийг мэдээлэл хариуцагчид өгөх;



Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах;

Мэдээлэл цуглуулах, боловсруулах явцад олж авсан мэдээллийг хадгалах;	Мэдээлэл цуглуулах, боловсруулах зорилго биелсэн бол мэдээлэл, түүнийг боловсруулсны үр дүнг хуулбар авч үлдэлгүйгээр хугацаанд нь өгөх, боловсруулахаар авсан мэдээллийг дахин ашиглах боломжгүйгээр устгах;	Мэдээлэл хариуцагчийн баталсан мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журмын хүрээнд мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг гүйцэтгэх.
---	---	--



Мэдээлэл хариуцагчийн хувьд мэдээлэл боловсруулагчид мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргээ шилжүүлж байгаа хэдий ч мэдээллийн эзний өмнө хариуцлага хүлээсэн хэвээр байдаг тул дан ганц гэрээ байгуулах нь хангалтгүй юм.

Иймд нэмэлтээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1

Мэдээлэл боловсруулагч мэдээллийг хамгаалахад шаардлагатай хяналт тавьж байгаа эсэхийг хянах, үнэлэх, мэдээлэл боловсруулагчтай тогтмол харилцах.

2

Мэдээлэл боловсруулагчтай анхлан гэрээ байгуулахдаа хоёр талын үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлох, өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлийг хянах, шаардлагатай тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

6 Дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн систем ашиглах

ДУУНЫ, ДҮРСНИЙ, ДУУ-ДҮРСНИЙ БИЧЛЭГИЙН СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?



Технологийн тусламжтайгаар **дуу, дүрс, дуу-дүрсний мэдээлэл** цуглуулах, дамжуулах, хадгалдаг техник хэрэгсэл, тэдгээр мэдээллийг дамжуулах хадгалах сүлжээ, төхөөрөмж, программ хангамжийг ойлгоно. **Жишээлбэл**, бидний сайн мэдэх утас, камер, дуу хураагуур зэрэг нь дуу, дүрс, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж юм.



Дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж болох тохиолдол:

- Нийтийн зориулалттай орон сууцны орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайд аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор.
- Ажлын байранд мэдээллийн аюулгүй байдлыг, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор.

Дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах, бичлэг ашиглахыг хориглосон байршил:

- Ариун цэврийн өрөө
- Хувцас солих өрөө
- Нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө
- Караокены өрөө
- Зочид буудлын өрөө
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө
- Бусад хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд
- Нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан
- Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөх.



Дээрх байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусад дамжуулсан бол **ГЭМТ ХЭРЭГ**. (Эрүүгийн хууль 13.8.4)

Дээрх байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулсан бол **ЗӨРЧИЛ**. (Зөрчлийн тухай хууль 6.22.4)

Хүний эрхийн Үндэсний Комиссоос хууль хяналтын байгууллагатай хамтран дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор шалгалт хийх эрхтэй.

АНХААРАХ!

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулхахт холбогдсон харилцааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.



7

Мэдээлэл хамгаалах журам, үйл ажиллагаа, хэрэгжилтийг хангах

аж ахуйн нэгж, байгууллагын аль алба хэлтэс энэ асуудлыг хариуцах вэ?

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөх нь зөвхөн хууль эрх зүй болон комплаенсийн алба нэгжид даатгах зүйл биш юм. Харин тус хуулийг дагаж мөрдөх нь аливаа аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй хүн бүрд хамааралтай байдаг.

Хүний хувийн мэдээллийг хэрхэн цуглуулж, боловсруулж, ашиглаж, хамгаалж байгаа талаар ил тод байхын тулд үйлчлүүлэгчид болон ажилтнууддаа хүний хувийн мэдээлэлтэй холбоотой мэдээллийн нууцлалын журам зэрэг журмууд, тэдгээрийн хэрэгжилтийг мэдэгдэх нь маш чухал юм.



Үйлчлүүлэгчид:

- Үйлчлүүлэгчид хувийн мэдээлэлтэйгээ холбоотой хүсэлт, гомдол гаргахдаа хэнтэй холбоо барихаа мэдэхийн тулд мэдээлэл хариуцагч байгууллагын холбоо барих мэдээллийг хялбар, хандах бүрэн боломжтой хэлбэрээр хүргэх.
- Аливаа хүсэлт, гомдлыг хүлээн авсан даруйд байгууллагын өөрийн мэдээлэл хамгаалах журам, үйл ажиллагаа, гомдол хүлээн авах, шийдвэрлэх явцын талаарх шаардлагатай мэдээллээр үйлчлүүлэгчийг хангахад бэлэн байх.
- Үйлчлүүлэгчид танай байгууллага хүний ямар хувийн мэдээллийг боловсруулдаг, яаж ашигладаг талаарх мэдээллээр хангаж шийдвэр гаргах боломжийг нь олгохын тулд мэдээлэл хадгалах журам, тус үйл ажиллагааны талаарх мэдээллээ өөрчлөлт орох бүрт тогтмол шинэчлэх. Энэ мэдээллээ ил тод байлгах.

Ажилтнууд:


- Ажилтнуудын хувийн мэдээллийг боловсруулахад тэдний өөрсдийн үүрэг, хариуцлагыг ойлгуулж бататгахын тулд ажилтны мэдээлэл хамгаалах журмыг танилцуулах.
- Мэдээллийн нууцлалын ач холбогдлыг байгууллагын ажилтнуудад ойлгуулж, энэ талаар мэдээлэл өгөх буюу үүнийг дахин давтагдаа шинжтэй үйл ажиллагаа болгож байгууллагадаа хүний хувийн мэдээлэл хамгаалах соёлыг бий болгох.
- Ажилтны хувийн мэдээллийг хамгаалах түүний ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд зурагт хуудас наах, цахим шуудан болон бусад харилцааны хэрэгслийг ашиглан энэ талаар мэдэгдэх.
- Хүний хувийн мэдээлэлтэй харьцдаг гол албан хаагчдаа сүүлийн үеийн хөгжил дэвшил, өөрчлөлтийн талаар байнга мэдээлэлтэй байлгаж, тогтмол сургалтанд хамруулах.

Хураангуй зөвлөмж

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГАЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Мэдээллийн эзний зөвшөөрөл

Мэдээллийн эзний зөвшөөрлийг бичгээр авч, зохих мэдээллийг мэдээллийн эзэнд танилцуулах




Дотоод журам

Хүний хувийн мэдээллэлтэй хэрхэн харьцах болон аюулгүй байдлыг хангах дотоод журам хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх

Зөрчил мэдэгдэх

Зөрчил гарсан тохиолдолд тухайн зөрчил болон авсан арга хэмжээний тухай бүртгэж, Хүний Эрхийн Үндэсний Комисст жил бүрийн 1 дүгээр сард хүргүүлэх.



Мэдээлэл боловсруулагч

Мэдээлэл боловсруулагчаар дамжуулан мэдээллийг цуглуулж, боловсруулж байгаа тохиолдолд мэдээлэл хариуцагч нь мэдээллийн эзний өмнө хариуцлага хүлээсэн хэвээр байдгийг анхаарах.

Ажилтны цагийн бүртгэл

Хурууны хээгээр бүртгэл хийх хориотой. Ажилтныг таних болон баталгаажуулахад хурууны хээнээс бусад биометрик мэдээллийг ашиглаж болох ч энэ нь нууц мэдээлэл тул ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.




Өөр зорилгоор ашиглах

Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор боловсруулах, ашиглахыг хориглоно. Өөр зорилгоор ашиглах, боловсруулах тохиолдолд дахин зөвшөөрөл авах ёстой.

Ажлын байрны дүрс бичлэг

Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд ажлын байранд зөвхөн мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүднээс дүрс бичлэг хийх бөгөөд анхааруулга байршуулах ёстой. Ажлын гүйцэтгэлийг дүрс бичлэгээр хянахгүй.



Хяналт

Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс хяналт тавина.

